



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/156

Хэрлэн сум

Цаг агаарт зориудаар нөлөөлж байгаль,
цаг уурын болзошгүй эрсдэлээс урьдчилан
сэргийлэх ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ой хээрийн түймрийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраахад дэмжлэг үзүүлэх, газар тариалан, бэлчээрийн ургамлын ургалтад шаардлагатай хөрсний чийг болон гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх, хуурайшилт, цөлжилтийг сааруулах зорилгоор аймгийн хэмжээнд цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх экспедицийн үйл ажиллагааны урсгал зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Экспедицийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж, шаардлагатай үед цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж тухай бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Б.Хэрлэнчимэг)-д үүрэг болгосугай.

4. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010435

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 25 өдрийн
А/Б/С захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Зардлын нэр	Санхүүжилт олгох сар			Нийт үнэ (төгрөг)
		2022.03	2022.04	2022.06	
1	Шатахуун		3000000	2000000	5000000
2	Томилолт		2600000	1000000	3600000
3	Автомашинны засвар, хөдөлмөр хамгаалал	1400000			1400000
	Дүн	1400000	5600000	300000	10000000